



# “ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 3 сарын 27 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,  
Төмөрчний гудамж - 8, 405 тоот  
Утас: +976 7711-4519

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН УДИРДЛАГАД

#### *Дүгнэлт*

Бид Техник импорт ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруул уудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Техник импорт ХК 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### *Дүгнэлтийн Үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

#### *Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага*

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шудрага бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### *Тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Техник импорт ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Лидер экаунт аудит ХХК  
Захирал Н.Шаравхорол  
2023 оны 3 сарын 27